

# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

03.16 - 03.20



Ковид-19-ийн тархалт бондын зах зээлд хэрхэн нөлөөлж буй болон Төвбанкны зүгээс авч буй арга хэмжээний тухай шинжээчийн булангаар хүргэж байна.

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** Шинэ Коронавирусийн цар тахлын дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөөллөөс үүдэн энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. S&P500 индекс 2017 оноос хойш байгаагүй доод цэгтээ хүрсэн бол, Dow Jones аж үйлдвэрийн дундаж индекс 2016 оноос хойших хамгийн доод цэгтээ хүрч буурсан байна.

Dow Jones аж үйлдвэрийн дундаж индекс 30 жилийн өмнөх "Хар даваа гараг" буюу 1987 оны 10-р сарын 19-өөс хойш байгаагүй өндөр хувь хэмжээгээр буурсан бол Nasdaq индексийн нэг өдрийн уналтын нь түүхэнд дээд хэмжээнд хүрсэн байна. Холбооны Нөөцийн Сангаас, Ням гарагт, бодлогын хүүний түвшинг 0.00%-0.25% хэмжээнд хүргэж буулгасан ба Үнэт цаасны болон Ипотекийн зээлээр баталгаажсан бондын худалдан авалтаа нэмэгдүүлнэ гэсэн мэдэгдэл хийсэн боловч хөрөнгө оруулагчид үнэт цаасаа эрчимтэй зарсаар байгаа юм. Мөн Даваа гарагт Chicago Board Options Exchange-ийн тооцон гаргадаг хөрөнгийн зах зээлийн хэлбэлзлийг хэмждэг CBOE Volatility Index нь 2008 оны санхүүгийн хямралын оргил үед байсан хэмжээнээс өндөр цэгт хүрч өссөн байна. Даваа болон Лхагва гарагт болсон огцом уналтуудаас үүдэн "circuit breaker" буюу "автомат унтраалга" дахин ажилласан байна. Мөн Нью-Йоркийн Хөрөнгийн Бирж (NYSE) 3-р сарын 23-аас эхлэн түр хугацаанд бүрэн автомат арилжаа явуулахаар болжээ.

**Европ:** Европын улс орнуудад хөл хорио тогтоосонтой холбоотой эдийн засгийн зогсонги байдалд ороод байгаагаас үүдэн энэ долоо хоногт хөрөнгийн зах зээлийн индексүүд их хэмжээний уналттай байлаа. Гэхдээ, эдийн засгийн идэвхжүүлэх хөтөлбөрүүд болон хүүний түвшинг бууруулснаас үүдэн долоо хоногийн сүүлээр бууралтын тодорхой хэмжээг нөхсөн байна.

Английн Төв Банк яаралтай хуралдаан зарлаж хүүний түвшинг 15 суурь пункт (bps) буюу 0.15%-аар бууруулж 0.10% болгон, хөрөнгийн худалдан авалтыг 200 тэрбум фунтээр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь сүүлийн 2 хоногт зах зээл сэргэхэд нөлөөлсөн байна. Европын Төв Банкнаас өнгөрсөн долоо хоногт зарласан 120 тэрбум еврогийн хөтөлбөрөөс гадна 750 тэрбум еврог Цар Тахлын Яаралтай Хөтөлбөр (Pandemic Emergency Program)-ийн хүрээнд засгийн газрын болон компанийн бондуудыг хамгаалахад зарцуулахаар болжээ.

**Япон:** Энэ 7 хоногт Японд Vernal Equinox Day баярын бүх нийтийн амралт болсонтой холбоотойгоор арилжааны богино долоо хоног нь хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй хаагдсан байна.

Reuters-ийн мэдээлснээр, Японы ерөнхий сайд Шинзо Абэ коронавирусаас болж ихээхэн хохирол амсаад буй эдийн засгаа хэрхэн сайжруулахыг хэлэлцэхээр Японы Банкны ерөнхийлөгч Харухико Курода зэрэг мэргэжлийн эдийн засагчдаас бүрдсэн комисс байгуулжээ.

**БНХАУ:** Энэ долоо хоногт Хятадын үнэт цаасны зах зээл уналттай байсан байна.

Хятадын Ардын Банк (PBoC) 3-р сарын 20-нд болсон мөнгөний бодлогын уулзалтаараа ХНС болон бусад 17 төв банкны шийдвэрээс зөрж, хүүний түвшинг бууруулахгүй гэсэн нь зах зээлийг гайхшруулсан юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,156.69	-2.42% ▼
Dow Jones	АНУ	19,173.98	-17.30% ▼
S&P 500	АНУ	2,304.92	-14.98% ▼
Nasdaq	АНУ	6,879.52	-12.64% ▼
S&P/TSX	Канад	11,851.81	-13.59% ▼
FTSE 100	Их Британи	5,190.78	-3.27% ▼
S&P/ASX 200	Австрали	4,816.60	-13.05% ▼
Nikkei 225	Япон	16,552.83	-5.04% ▼
Hang Seng	Хонг Конг	21,709.13	-10.70% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	87.69
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	83.86
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	83.08
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	97.56
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	102.53
DBM' 2023	USD	7.250%	83.24
TDBM' 2020	USD	9.375%	99.55
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	90.38

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.929	0.13 ▲
Libor 3M	1.204	0.36 ▲
Libor 6M	0.994	0.17 ▲
Libor 1YR	0.934	0.11 ▲
US 2YR Bond	0.293	0.02 ▲
US 3YR Bond	0.323	-0.01 ▼
US 5YR Bond	0.422	0.01 ▲
US 10YR Bond	0.809	0.14 ▲

Валютын ханш	2020.03.20	Өөрчлөлт
USD	2,770.76	0.12% ▲
CNY	392.69	-0.85% ▼
EUR	2,996.58	-3.23% ▼
RUB	35.52	-6.28% ▼
KRW	2.24	-1.32% ▼
JPY	25.30	-3.25% ▼
CAD	1,948.36	-2.53% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,498.65	-2.04% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	12.62	-14.29% ▼
Зэс	USD/lb.	217.15	-11.87% ▼
Нүүрс	USD/MT	66.83	1.88% ▲
WTI газрын тос	USD/bbl.	22.43	-29.31% ▼
Brent газрын тос	USD/bbl.	26.98	-20.30% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. II	6.4%
Бодлогын хүү	2020. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. II	10.95 %
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. II	11.33%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. II	4.71%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. II	17.01%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. II	10.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 52 компанийн 425.9 сая төгрөгийн 2,078,965 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Хар Хорум Пропертийс” /AMT/ компанийн хувьцаа 57.67%-аар буюу хамгийн ихээр өсөж 141.43 төгрөг хүрч хаагдсан бол “Лэндмн ББСБ” /LEND/ компанийн хувьцаа 18.64%-аар буурч 28.46 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

03-р сарын 20-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,691.0 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,156.69 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.42%-аар буурсан байна.

MSE Индекс



Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2020 он/



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	425.9	
Зах зээлийн үнэлгээ	2,690,957.5	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,156.69	-2.42% ▼
MSE I индекс	8,828.15	-2.25% ▼
MSE II индекс	7,671.77	-0.66% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Ард санхүүгийн нэгдэл	80,288	121,138,833
Хар хорум пропертийс	682,582	88,984,983
АПУ	132,066	82,695,136
Говь	112,825	23,670,014
Таван толгой	2,582	16,790,620

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Хар хорум пропертийс	141.43	57.67% ▲
Жуулчин дюти фри	82,000.00	12.02% ▲
Би Ди Сек	897.04	11.92% ▲
Эрдэнэ ресурс девелопмент корп	525.00	9.38% ▲
Стандарт агрикалчер групп	80.00	3.90% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Лэндмн ББСБ	28.46	-18.64% ▼
Хэрлэн хивс	36.00	-7.69% ▼
Шивээ овоо	2,000.00	-6.98% ▼
Улсын их дэлгүүр	1,258.00	-6.68% ▼
Монгол шевро	1,690.00	-6.11% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард секюритиз	284,362,688
Эс Жи Капитал	152,802,198
БиДиСек	84,756,465
Апекс Капитал	60,423,525
Стандарт инвестмент	53,341,317

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	622.32	662,261
Таван толгой	6,500.00	342,324
МИК Холдинг	13,890.00	287,652
Инвексор ББСБ	2,600.00	186,493
Говь	207.60	161,951

### Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	NA	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	NA	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	NA	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	NA	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	NA	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	NA	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	NA	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	NA	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	NA	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	NA	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	NA	2020.05.01-ЭЭС

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


### ОНЦЛОХ МЭДЭЭ



“Компанийн тухай хууль”-ийн дагуу хувьцаат компаниуд жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 5-р сарын 1-ний өдрийн дотор хуралдуулах үүрэг хүлээсэн байдаг. Энэ жилийн хувьд онцгой нөхцөл байдалтай учраад байгаа буюу COVID-19 халдварын улмаас Засгийн газраас олон хүн цуглуулсан арга хэмжээ, хурал цуглаан 3-р сарыг дуустал хийхийг хориглоод байгаа юм. Үүнтэй холбоотой Санхүүгийн Зохицуулах Хорооноос өөрийн цахим хуудсаараа дамжуулан хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахим хэлбэрээр хийх зөвлөмжийг хүргүүлээд байгаа юм.

### ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

- “Ган Хэрлэн” /MSE:HZB/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2-р сарын 16-ны өдрийн №01/20 тоот тогтоолоор 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 150 төгрөг, нийт 14.9 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болов.
- “Ган хэрлэн” /MSE:HZB/ компани хэлбэрээ өөрчлөх замаар хөрөнгийн захаас гарахаар төлөвлөж байна.
- “Лэндмн ББСБ” /MSE:LEND/-ийн хувьцааны ханш 3-р сарын 20-ны өдөр 10.11%-аар унаж 28.46 төгрөг дээр хаагдсан байна. Ингэснээр компанийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш хамгийн доод түвшинд хүрч байгаа юм.
- Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD; MSE:ERDN) 2019 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн мэдээллээс гадна COVID-19 вирустэй холбоотой нөлөөллийн тухай танилцууллаа.



### БУСАД МЭДЭЭ

Монголбанк энэ 7 хоногт 2 удаагийн дуудлага худалдаагаар 60.1 сая ам.доллар нийлүүлэв. Задлаад харвал Мягмар гарагт банкнуудын саналыг 100 хувь биелүүлж, 35.1 сая ам.доллар ялгаатай ханшаар нийлүүлсэн байна. Мөн Пүрэв гарагт ирүүлсэн саналыг 100 хувь биелүүлж, 25 сая ам.доллар ялгаатай ханшаар нийлүүлжээ. Монголбанк 3-р сард болсон бүх дуудлага худалдаанд оролцож, валютын захад идэвхтэй нийлүүлэлт хийж байна. 3-р сарын нэгнээс 19-нийг хүртэл 193 сая ам.доллар нийлүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад долоо дахин өндөр дүн болж байгаа аж. Хэдий тийм боловч төгрөгийн ам.доллартай тэнцэх ханш таван өдөр дараалан суларснаар 2,769.17 төгрөгтэй тэнцэж байна. Он гарснаас хойш төгрөг 1.2%-р суларчээ.

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

- Н.Энхбаяр: Эдийн засгаа дэмжье гэвэл төсөвт тодотгол хийж, тодорхой хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг чөлөөлж авах ёстой.
- Ч.Хашчулуун: Эдийн засаг 2009 оныхтой ойролцоо эсвэл түүнээс илүү хэмжээгээр унах магадлалтай.
- УОК: Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг 4-р сарын 30 хүртэл сунгаж байна.
- Fitch Solutions: БНХАУ-ын эрэлт энэ оны турш буурч, Монголоос импортлох түүхий эдийн хэмжээ багасаж мэднэ.



### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Коронавирус (Covid-19)-ийн тархалттай холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт хүндрэл учирч, банкны салбарын зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсэж байгаатай холбогдуулан Монголбанкнаас дараах журмуудын зохицуулалтыг түр хугацаагаар буюу 2020 оны 1-р сарын 31-ний өдрөөс 2020 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл өөрчлөн мөрдүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд:

1. “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”
2. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”

Дээрх зохицуулалтын хугацаа дуусах үед дээрх журмуудыг ердийн зохицуулалтын дагуу мөрдөхөөр шийдвэрлэлээ.

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улсын эрдэс бүтээгдэхүүний экспортын 80 гаруй хувь нь БНХАУ-д хамаардаг учраас тус улсын эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарах нь тодорхой байдаг бөгөөд COVID-19 халдварын улмаас БНХАУ-ын эдийн засгийн бодит өсөлтийн таамгаа 5.9 хувь байсныг 4.2 хувь болгосноо “Fitch Solutions” мэдээлсэн. Үүнтэй хамааралтайгаар энэ оны туршид БНХАУ-ын эрэлт буурч, Монголоос импортлох түүхий эдийн хэмжээ багасаж магадгүй байна. Ийм нөхцөл үүсвэл Монголын эдийн засагт хүндхэн цохилт болж, ажилгүйдэл нэмэгдэж болзошгүйг 03-р сарын 19-нд гаргасан тайландаа дурджээ.



## ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

### КОВИД-19 БА БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ

Коронавирусын тархалт нэмэгдэх болгоомжлол улам бүр нэмэгдэж хөрөнгө оруулагчид их хэмжээгээр хөрөнгөө зарж байгаа ба санхүүгийн зах зээлд эрсдэлгүй хэмээн үзэгддэг хөрөнгүүдийн ч ханш унаж эхэллээ.

Ялангуяа, хөрөнгө оруулагчдын дунд зах зээлийн тодорхойгүй байдал их үед хамгийн аюулгүй хэмээн үзэгддэг Засгийн Газрын Үнэт Цаасны (ЗГҮЦ) ханш Лхагва гарагт уналтад орсон байна.

#### Бондын зах зээлд

Хямралын үеүдэд ЗГҮЦ-ыг хөрөнгө оруулагчид хамгийн аюулгүй хөрөнгө оруулалт хэмээн үздэг ба Коронавирусын тархалтын эхэн үед зах зээлд энэхүү зарчим ажиглагдсан буюу ЗГҮЦ-ны ханш ихсэн өгөөж түүхэн доод хэмжээндээ хүрээд байсан билээ.

Гэвч энэ долоо хоногийн Лхагва гарагт хөрөнгө оруулагчид эзэмшиж буй бондуудаа их хэмжээгээр зарж эхэлсэн ба Лхагва гарагт АНУ-ын ЗГ-ын 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 1.2%-ийн давсан нь өнгөрөгч 2 долоо хоногийн хамгийн их үзүүлэлт болсон ба 03-р сарын 09-ний доод хэмжээ болох 0.4%-аас 3 дахин их байгаа юм.

Харин Европын зах зээлийн жишиг болох ХБНГУ-ын ЗГ-ын 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж -0.23% хүртэл өсөн сүүлийн 2 сарын дээд хэмжээндээ хүрсэн бол Их Британи улсын 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 0.79% хүртэл өссөн байна.

#### Шалтгаан

Хөрөнгө оруулагчид их хэмжээгээр хөрөнгөө зарж буй шалтгаан нь товчхондоо бэлэн мөнгөтэй байх сонирхол юм. Хувьцаа болон компанийн бондын ханш буурснаас үүдэн харилцагчид сангуудаас мөнгөө эргүүлэн татаж эхэлсэн байна. Энэхүү мөнгийг гаргаж өгөхийн тулд хөрөнгө оруулагчид зарахад хамгийн хялбар хөрөнгөө зарахаас өөр аргагүй болж байгааг сангууд мэдээлэлжээ.

Дэлхийд хамгийн их арилжаалагддаг үнэт цаасны хувьд ЗГҮЦ-ууд зарахад хамгийн хялбар хэрэгсэл ба “Олон хүмүүс боломжтой зүйлээ зарах гэж л хичээж байна” гэж Principal Global Investors-ийн ерөнхий стратегич Сиема Шах хэлэв.

#### Төв банкнуудын хариу үйлдэл

Төв банкнууд, ханшийн бууралтын зогсоохоор хүчин чармайлт гарган ажилласаар байна. АНУ-ын Холбооны Нөөцийн Сангаас өнгөрөгч Ням гарагт хүүгийн түвшинг 0-тэй ойр хэмжээ хүртэл бууруулсан ба 700 тэрбум ам.долларын бондын худалдан авалт хийхээ мэдэгдсэн ба сүүлийн өдрүүдэд богино хугацаат үнэт цаасны зах зээлд хийх интервенцийн хэмжээгээ нэмэгдүүлсэн.

Харин Европын Төв Банк (ЕТБ) Лхагва гарагт өмнөх бонд худалдан авах хөтөлбөр амжилтгүй болсонтой холбоотой яаралтай хуралдаан зарлан 750 тэрбум еврогийн нэмэлт хөрөнгө худалдан авалт хийхээр болсон байна. Энэхүү үйлдэл нь ХБНГУ-ын ЗГҮЦ-ны өгөөжийн бага хэмжээгээр бууруулсан ч удалгүй ханш дахин уналтад орсон байна.

Хэдийгээр Төв банкнууд арга хэмжээ авсаар байгаа ч ЗГҮЦ-уудын ханш вирусийн тархалтын эхэн үед байсан хэмжээндээ хүрч чадахгүй байсаар байгаа юм.

#### Дүгнэлт

Бондын ханш буурсаар байгаа нь хөрөнгө оруулагчдын эцсийн аюулгүй хөрөнгө оруулалтын боломжийн хааж байгаа ба санаа зовнисон хөрөнгө оруулагчид их хэмжээний бэлэн мөнгөтэй байна. Зах зээлийн тогтворгүй байдлын үед ханш нь өсдөг бас нэг хэрэгсэл болох алтны ханш мөн сүүлийн 2 долоо хоног бууралттай байлаа.

Ноён Шах “Хөрөнгө оруулагчдад нуугдах газар үлдсэнгүй. ЗГҮЦ-ны ханшид тохиолдож буй үйл явдал зах зээлд гажуудал байгааг харуулж байна” гэжээ.

Эх сурвалж: Financial Times

#### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.